



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/13/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН 2021
ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН
ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Г.Баянжаргал

Утас: 70273204 Цахим хаяг: bayanjargalg@audit.gov.mn

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	16
3.8 Аудитын гол асуудал.....	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
4. Аудитын илрүүлэлт	18
4.1 Залруулсан алдаа	18
4.4 Зөвлөмж	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
НХМ	Нэг хэвийн маягт
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ХАӨМС	Хүн ам, өрхийн мэдээллийн сан
ХАОСТ	Хүн ам, орон сууцны тооллого
ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100 Зуунмод, Төв аймаг
Утас: 70272248, Факс: 70272582, Иймэйл: tuv@audit.gov.mn

2022.02.24 № 01/47
танай _____ -ны № _____ -т

ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА Ж.ОТГОНЧУЛУУН ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

19020228

D 2022/2022 он/ALBAN BICHIG

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/Төгрөгөөр/ Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	22,451,249.00	6,134,309.00
35	БАРАА МАТЕРИАЛ	6,033,249.00	6,134,309.00
354	Хангамжийн материал	6,033,249.00	6,134,309.00
35410	Бичиг хэргийн материал	4,750,640.00	4,691,900.00
35420	Аж ахуйн материал	433,109.00	584,909.00
35440	Түлш, шатах тослох материал	560,000.00	620,000.00
35470	Бусад хангамжийн материал	289,500.00	237,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	27,033,660.96	42,096,348.37
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	27,033,660.96	42,096,348.37
392	Биет хөрөнгө	27,033,660.96	42,096,348.37
39203	Авто-тээврийн хэрэгсэл	29,375,000.00	29,375,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-29,375,000.00	-29,375,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	44,870,205.09	68,290,805.09
39206	Хуримтлагдсан элэгдэл	-18,571,725.86	-26,649,176.60
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	5,714,493.00	5,714,493.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-4,979,311.27	-5,259,773.12
39301	Програм хангамж	520,000.00	520,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-520,000.00	-520,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	49,484,909.96	48,230,657.37
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	49,484,909.96	48,230,657.37
51	Засгийн газрын хувь оролцоо	49,484,909.96	48,230,657.37
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	11,793,337.71	11,793,337.71
51101	Өмч: - төрийн	11,793,337.71	11,793,337.71
512	Хуримтлагдсан үр дүн	37,691,572.25	36,437,319.66
51210	Өмнөх үеийн үр дүн	37,691,572.25	37,691,572.25
51220	Тайланг үеийн үр дүн	00.00	-1,254,252.59
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	49,484,909.96	48,230,657.37

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	/Төгрөгөөр/ Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	421,794,010.00	251,046,618.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	20,283,981.00	10,661,200.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	10,661,200.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	10,661,200.00
120017	үнэ төлбөргүй хүлээн авсан орлого үндсэн хөрөнгө		10,551,200.00
120018	үнэ төлбөргүй хүлээн авсан орлого бараа материал	00.00	110,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	401,510,029.00	240,385,418.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	111,301,000.00	115,396,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	111,301,000.00	115,396,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	290,209,029.00	124,989,318.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	290,209,029.00	124,989,318.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	384,663,861.35	252,300,870.59
21	УРСГАЛ ЗАРДАЛ	384,663,861.35	252,300,870.59
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	375,287,304.27	249,087,707.39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	120,375,517.29	130,658,647.80
210101	Үндсэн цалин	87,953,066.41	97,143,684.83
210102	Нэмэгдэл	19,798,525.38	22,643,402.22
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,787,720.00	4,365,209.35
210104	Урамшуулал	5,836,205.50	6,506,351.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,442,352.76	16,307,478.00
210201	Тэтгэврийн даатгал	10,760,717.92	11,593,168.00
210202	Тэтгэмжийн даатгал	927,585.88	1,307,325.00
210203	ҮОМШО-ний даатгал	739,428.74	1,045,857.00
210204	Ажилгүйдлийн даатгал	169,774.54	207,415.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,844,845.68	2,153,713.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,297,862.00	25,608,192.00
210401	Бичиг хэрэг	3,283,780.00	5,176,490.00
210402	Тээвэр, шатахуун	17,170,000.00	19,745,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,440,082.00	503,482.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	404,000.00	77,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	00.00	106,220.00
2107	Томилолт, зочны зардал	18,880,000.00	17,861,000.00
210702	Дотоод албан томилолт	18,880,000.00	17,861,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	191,356,945.87	47,070,477.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	189,952,515.87	46,867,397.00
210803	Даатгалын үйлчилгээ	70,800.00	54,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	133,830.00	134,280.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	14,800.00	14,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,168,526.35	11,581,912.59
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	3,224,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	4,168,526.35	8,357,912.59
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,376,557.08	3,213,163.20
2132	Бусад урсгал шилжүүлэг	246,000.00	176,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	246,000.00	176,400.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,130,557.08	3,036,763.20
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,130,557.08	3,036,763.20
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	37,130,148.65	-1,254,252.59
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	37,130,148.65	-1,254,252.59

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	401,510,029.00	256,803,418.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	111,301,000.00	256,803,418.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	111,301,000.00	115,396,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	111,301,000.00	115,396,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	290,209,029.00	141,407,318.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	290,209,029.00	124,989,318.00
131107	Урьд оны үлдэгдлээс санхүүжих-Нэмэлт	00.00	16,418,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	401,510,029.00	243,934,018.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	401,510,029.00	243,934,018.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	375,715,471.00	240,701,254.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	120,279,701.16	123,915,403.07
210101	Үндсэн цалин	87,833,070.28	90,400,440.10
210102	Нэмэгдэл	19,798,525.38	22,643,402.22
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,774,400.00	4,365,209.35
210104	Урамшуулал	5,873,705.50	6,506,351.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,442,349.76	15,583,785.73
210201	Тэтгэврийн даатгал	10,760,714.92	11,753,809.32
210202	Тэтгэмжийн даатгал	927,585.88	957,394.12
210203	ҮОМШӨ-ний даатгал	739,428.74	766,035.33
210204	Ажилгүйдлийн даатгал	169,774.54	191,458.79
210205	Эрүүл мэндийн даатгал	1,844,845.68	1,915,088.17
2104	Хангамж, бараа материалын зардал	21,540,462.00	20,102,672.00
210401	Бичиг хэрэг	541,380.00	514,300.00
210402	Тээвэр, шатахуун	17,140,000.00	18,620,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,395,082.00	528,482.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	464,000.00	439,890.00
2107	Томилолт, зочны зардал	11,448,000.00	17,808,000.00
210702	Дотоод албан томилолт	18,880,000.00	17,808,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	196,572,959.00	59,763,894.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	194,892,029.00	58,246,964.00
210803	Даатгалын үйлчилгээ	70,800.00	54,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	133,830.00	134,280.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	14,800.00	14,800.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,461,500.00	1,313,850.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	3,527,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	25,794,557.08	3,527,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,794,557.08	3,232,763.20
2132	Бусад урсгал шилжүүлэг	246,000.00	196,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	246,000.00	196,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	25,548,557.08	3,036,763.20
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	25,548,557.08	3,036,763.20

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	12,869,400.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	12,869,400.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	12,869,400.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	12,869,400.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	12,869,400.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-12,869,400.00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	/ төгрөгөөр / Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,793,337.71	00.00	561,423.60	00.00	12,354,761.31
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	11,793,337.71	00.00	561,423.60	00.00	12,354,761.31
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	51,277,023.57	00.00	51,277,023.57
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,793,337.71	00.00	37,691,572.25	00.00	49,484,909.96
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,793,337.71	00.00	37,691,572.25	00.00	49,484,909.96
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	11,793,337.71	00.00	37,691,572.25	00.00	49,484,909.96
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-1,254,252.59	00.00	-1,254,252.59
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,793,337.71	00.00	36,437,319.66	00.00	48,230,657.37

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	111,301,000.00	103,425,565.92	115,396,100.00	114,588,962.28
21	УРСГАЛ ЗАРДАЛ	111,301,000.00	103,425,565.92	115,396,100.00	114,588,962.28
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	111,055,000.00	103,179,565.92	115,199,300.00	114,392,962.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	93,885,200.00	87,747,080.16	97,959,500.00	97,854,502.55
210101	Үндсэн цалин	63,764,500.00	57,375,749.28	66,346,800.00	64,339,539.58
210102	Нэмэгдэл	19,621,400.00	19,798,525.38	21,113,400.00	22,643,402.22
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,342,400.00	5,337,600.00	5,342,400.00	4,365,209.35
210104	Урамшуулал	5,156,900.00	5,235,205.50	5,156,900.00	6,506,351.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,674,500.00	11,243,993.76	13,224,600.00	12,698,507.73
210201	Тэтгэврийн даатгал	8,919,000.00	7,562,358.92	9,306,200.00	8,868,531.32
210202	Тэтгэмжийн даатгал	938,900.00	927,585.88	979,600.00	957,394.12
210203	ҮОМШӨ-ний даатгал	751,100.00	739,428.74	783,700.00	766,035.30
210204	Ажилгүйдлийн даатгал	187,800.00	169,774.54	159,900.00	191,458.79
210205	Эрүүл мэндийн даатгал	1,877,700.00	1,844,845.68	1,959,200.00	1,915,088.17
2104	Хангамж, бараа материалын зардал	2,655,400.00	2,654,262.00	2,357,600.00	2,282,672.00
210401	Бичиг хэрэг	541,400.00	541,380.00	514,300.00	514,300.00
210402	Тээвэр, шатахуун	945,800.00	945,000.00	803,900.00	800,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	704,200.00	703,882.00	598,600.00	528,482.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	464,000.00	464,000.00	440,800.00	439,890.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,536,400.00	1,534,230.00	1,354,100.00	1,253,780.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	507,300.00	507,300.00	405,800.00	324,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	70,800.00	70,800.00	70,800.00	54,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	136,000.00	133,830.00	136,000.00	134,280.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	14,800.00	14,800.00	14,800.00	14,800.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	807,500.00	807,500.00	726,700.00	726,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	303,500.00	0.00	303,500.00	303,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	303,500.00	00.00	303,500.00	303,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	246,000.00	246,000.00	196,800.00	196,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	246,000.00	246,000.00	196,800.00	196,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	111,301,000.00	103,425,565.92	115,396,100.00	114,588,962.28
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	111,301,000.00	103,425,565.92	115,396,100.00	114,588,962.28
131001	Улсын төсвөөс санхүүжих	111,301,000.00	103,425,565.92	115,396,100.00	114,588,962.28
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих				
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	08	07	07	07
620001	Удирдах ажилтан	01	01	01	01
620002	Гүйцэтгэх ажилтан	05	04	04	04
620003	Үйлчлэх ажилтан	02	02	02	02
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	08	07	07	07
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	06	05	05	05
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	02	02	02	02

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл / төгрөгөөр /
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	272,535,906.00	139,177,692.52
21	УРСГАЛ ЗАРДАЛ	272,535,906.00	139,177,692.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	272,535,906.00	139,177,692.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	32,532,621.00	26,060,900.52
210101	Үндсэн цалин	30,457,321.00	26,060,900.52
210102	Нэмэгдэл	1,436,800.00	00.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	638,500.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,198,356.00	2,885,278.00
210201	Тэтгэврийн даатгал	3,198,356.00	2,885,278.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,886,200.00	17,820,000.00
210402	Тээвэр, шатахуун	16,195,000.00	17,820,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,691,200.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,000,000.00	00.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,000,000.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	18,880,000.00	17,808,000.00
210701	Гадаад албан томилолт	18,880,000.00	17,808,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	195,038,729.00	71,379,514.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	194,384,729.00	70,792,364.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	654,000.00	587,150.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	3,224,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		3,224,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	0.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	272,535,906.00	139,177,692.52
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	272,535,906.00	139,177,692.52
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	272,535,906.00	123,296,392.52
131107	Урьд оны үлдэгдлээс санхүүжих-Нэмэлт	00.00	15,881,300.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	00.00	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд хөрөнгийн тооллого, тооцоо бодолттой холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Баянжаргал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс нь аймгийн хэмжээнд албан ёсны статистикийн үйл ажиллагааг хараат бус бие даасан зарчмаар эрхлэн явуулж, бүх хэрэглэгч нарт адил тэгш үйлчилгээ үзүүлэх эрхэм зорилгын дор статистик мэдээ тайлан цуглуулах, дамжуулах, боловсруулах, хянах, тархаах, мэдээний бодит байдал, уялдаа холбоо, шуурхай, хүртээмжтэй байдлыг сайжруулах, тооллого судалгааны мэдээллийн үр өгөөжийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулдаг, Үндэсний статистикийн хорооны харьяа байгууллага юм.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хууль тогтоомжийн биелэлтийг ханган ажиллах
- Анхан шатны мэдээллийн чанарт ахиц дэвшил гаргах, мэдээллийн үнэн бодит байдлыг дээшлүүлэх
- Статистикийн дүн шинжилгээний чадавхийг бэхжүүлэх, шинжилгээ судалгааны ажлыг өргөжүүлэх
- Хэрэглэгчдийн статистикийн боловсролыг дээшлүүлэх, статистикийн мэдээллийн хэрэглээ, ашиглалтыг нэмэгдүүлэх, сурталчлан таниулах
- Статистикийн салбарын чадавхыг бэхжүүлэх, төв орон нутгийн байгууллагын үйл ажиллагааны уялдааг сайжруулах

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд

хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн дотоод аудитын чиг үүрэг, түүний үйл ажиллагааг Үндэсний статистикийн хорооны дотоод аудит, мониторингийн хэлтэс болон аймгийн Санхүү хяналт, аудитын алба гүйцэтгэдэг.

ҮСХ-ны дотоод аудит, мониторингийн хэлтсээс шилэн дансны хуулийн хэрэгжилтэд улирал бүр хяналт тавьж, хэрэгжилтийг Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2021 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн 12 тоот албан бичгээр болон 2021 оны 8 дугаар сарын 25-ны өдөр биелэлтийн тайлан гаргаж хүргүүлсэн байна.

Аймгийн Санхүү хяналт, аудитын алба 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй боловч 2019, 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт хийж Бага эрсдэлтэй гэж тодорхойлон “Шатахууныг замын хуудсыг үндэслэн жолоочийн тооцоог бодож байх” албан шаардлага хүргүүлсэн талаар ойлголт олж авснаар дараагийн аудитаар анхаарах асуудлаар тодорхойлж байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл Бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас 2,0 хувиар буюу 7,693.3 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 6,154.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөх үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Энэ нь төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн

тайлангийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцсон тул дахин тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас 2,0 хувиар буюу 5,046.0 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 4,036.8 мянган төгрөгөөр тогтоосон. Дахин шинэчлэн тооцсон материаллаг байдлын түвшин нь төлөвлөлтийн үе шатнаас 2,117.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Энэ нь 2020 онд 10 жилд нэг удаа явагддаг ХАОСТ зохион байгуулагдсан тул нийт зардал буурсантай холбоотой дахин тооцсон.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Статистикийн тухай хууль, ТБОНӨ-ийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны санхүүгийн байдал, үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартад шаардсан зарчмын дагуу нягтлан бодох бүртгэлийн аккрузал сууриар бэлтгэн тайлагнасан байна.

Санхүүгийн “Acolous” программыг ашиглаж нягтлан бодох бүртгэлийг хөтөлж байна.

Орлого:

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс нь 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайланд улсын төсвөөс урсгал үйл ажиллагааны санхүүжилт 115,396.1 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн орлого 124,989.3 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 10,661.2 мянган төгрөг, нийт үйл ажиллагааны орлогыг 251,046.6 мянган төгрөгөөр, мөнгөн гүйлгээний тайланд урсгал үйл ажиллагааны санхүүжилт 115,396.1 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн орлого 141,407.3 мянган төгрөг, нийт үйл ажиллагааны мөнгөн орлогыг 256,803.4 мянган төгрөгөөр тайлагнасан байна.

Зардал:

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс нь 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар 252,300.9 мянган төгрөг, мөнгөн гүйлгээний тайлангаар 243,934.0 мянган төгрөг, төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 253,766.7 мянган төгрөг зарцуулсан байна.

Өмнөх оноос 161,124.6 мянган төгрөгөөр буурсан нь 2020 онд 10 жилд нэг удаа явагддаг ХАОСТ зохион байгуулагдсантай холбоотой байна.

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө:

Тус байгууллага төрийн сангийн 100140026001 тоот дансанд 2021 онд 115,396.1 мянган төгрөгийн орлого, 115,396.1 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж, 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл 0 төгрөг байна. Мөн нэмэлт санхүүжилтийн 100140026401 тоот дансанд 141,407.3 мянган төгрөгийн орлого төвлөрч, 141,407.3 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж үлдэгдэл 0 төгрөг байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:

Үндсэн хөрөнгө дансны эхний үлдэгдэл 80,479.7 мянган төгрөг, тайлант онд худалдаж авсан 12,869.4 мянган төгрөг, ҮСХ-оос үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 10,551.2 мянган төгрөг, нийт 23,420.6 мянган төгрөгийн хөрөнгө орлого авч, эцсийн үлдэгдэл 103,900.3 мянган төгрөгийн хөрөнгө байна.

Бараа материалын дансны эхний үлдэгдэл 6,033.2 мянган төгрөг, тайлант онд худалдаж авсан 35,817.9 мянган төгрөг, ҮСХ-оос үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 110.0 мянган төгрөг, нийт 35,927.9 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, 35,826.9 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, эцсийн үлдэгдэл 6,134.3 мянган төгрөгийн бараа материал байна.

Авлага, өглөгийн талаар:

2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд татаас санхүүжилтийн авлагын үлдэгдэл 16,418.0 мянган төгрөг байсан. ҮСХ-оос 2021 оны 03 дугаар сарын 16-ны өдөр сургалт зохион байгуулах зориулалттай ирсэн санхүүжилтээр авлага хаагдаж, авлагын данс үлдэгдэлгүй болсон байна.

Өглөгийн данс эхний болон эцсийн үлдэгдэлгүй, харилцагч бэлтгэн нийлүүлэгч 15 байгууллагуудтай тооцоо нийлж баталгаажуулсан байна.

Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн болон нэмэлт санхүүжилтийн данс, арилжааны банкны харилцах данс үлдэгдэлгүй байна. Бараа материал 6,134.3 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 42,096.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	16,418.0	0	-16,418.0
Урьдчилгаа	0	0	
Бараа материал	6,033.2	6,134.3	101.1
Үндсэн хөрөнгө	27,033.7	42,096.4	15,062.7
Нийт хөрөнгө	49,484.9	48,230.7	-1,254.2

Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	49,484.9	48,230.7	-1,254.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	49,484.9	48,230.7	-1,254.2

Авлагын дансны эцсийн үлдэгдэлгүй болж, авлага оны эхний үлдэгдлээс 16,418.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 6,134.3 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 101.1 мянган төгрөгөөр өссөн нь ҮСХ-оос 110.0 мянган төгрөгийн тэмдэг дардас үнэ төлбөргүй шилжүүлж авснаар бараа материалын үлдэгдэл өсөхөд шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 42,096.4 мянган төгрөг болж 15,062.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд хэлтсийн даргын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/04 тоот тушаалаар "Сорос компьютер" ХХК, Ай Ти Зон ХХК-аас 12,689.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг худалдан авч, ҮСХ-оос "Ухаалаг засаглал" төслийн хүрээнд үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 10,551.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмж орлогоор бүртгэж, нийт 23,420.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэнээс болон тайлант оны элэгдлийн зардал 8,357.9 мянган төгрөгөөр байгуулснаас шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 48,230.7 мянган төгрөг болж 1,254.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд улсын төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 264,957.9 мянган төгрөгөөр төлөвлөн, бараа ажил үйлчилгээний урсгал зардалд 136,847.9 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 128,110.0 мянган төгрөг санхүүжүүлэхээр дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 153,656.8 мянган төгрөгөөр бууруулан улсын төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 111,301.1 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь бараа ажил үйлчилгээний урсгал зардлыг 25,546.8 мянган төгрөгөөр бууруулж, хөрөнгийн зардалд 128,110.0 мянган төгрөгийг батлаагүйтэй холбоотой байна.

ҮСХ-оос 2021 оны 3, 7 дугаар саруудад тодотголоор 4,095.0 мянган төгрөгөөр улсын төсвөөс санхүүжих эх үүсвэрийг нэмэгдүүлж, 115,396.1 мянган төгрөгийн санхүүжилтийг батласан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар улсын төсвөөс 115,396.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаандаа 114,589.0 мянган төгрөгийг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 807.1 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 114,589.0 мянган төгрөг буюу 99,3 хувьтай зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд ҮСХ-оос Өртгийн зэрэгцүүлсэн судалгаа, Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа, ажиллах хүчний судалгаа, хүүхдийн хөдөлмөрийн судалгаа, бичил уурхайн туршилтын судалгаа, статистикийн бусад тооллого судалгаанд зориулагдсан 124,989.3 мянган төгрөгийн, 27 сумын статистик хариуцсан ажилтан, 97 багийн Засаг дарга нарт зориулсан ХАӨМС, Малын тооллого, ХАА ААНБ-ын жил, улирал, сарын цахим программ хангамжийн талаар мэдлэг олгож үйл ажиллагаандаа хэрэглэх чадвар эзэмшүүлэх сургалтад зориулагдсан 16,418.0 мянган төгрөгийн санхүүжилт хуваарилагдан ирүүлснээс цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардалд 26,060.9 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардалд 2,885.3 мянган төгрөг, тээвэр шатахууны зардалд 17,820.0 мянган төгрөг, дотоод албан томилолтод 17,808.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт 70,792.4 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 3,224.0 мянган төгрөг, нийт 139,177.7 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 2,229.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Таван жилд нэг удаа явагддаг ААНБ-ын улсын тооллого 2021 оны 12 дугаар сарын 01-нээс 12 дугаар сарын 31-ний хооронд явагдсан.

Үүнд төсөвт байгууллага, салбар компани, хувиараа хөдөлмөр эрхлэгч, ХХК, ХК, Төрийн бус байгууллага, нийт 3400 орчим нэгж тоолоход 35 тоологч ажиллаж 7,910.7 мянган төгрөгийн зардал гарсан байна.

Жендер ба хүрээлэн буй орчин судалгаа, Бичил уурхай эрхлэгчдийн судалгааг 2021 оны 8 дугаар сарын 25-с 11 дүгээр сарын 30 хүртэл зохион байгуулахад 500 иргэн хамруулах төлөвлөгөөтэй 12,973.7 мянган төгрөгийн санхүүжилт ирсэн. Сэргэлэн, Заамар сумдыг сонгон гар аргаар ашигт малтмал олборлогч хамрагдсан судалгаанд хамрагдсан 451 хүн бүрт 5.0 мянган төгрөгийн урамшуулал олгож уг судалгааг хийсэн 12 судлаачид урамшуулал, авто машин хөлслөх зардалд нийт 12,191.9 мянган төгрөг зарцуулж үлдсэн 781.8 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

ҮСХ-оос “Ухаалаг засаглал” төслийн хүрээнд үнэ төлбөргүй шилжиж ирсэн 4ш суурин компьютерыг 10,551.2 мянган төгрөгөөр машин тоног төхөөрөмж дансанд, 110.0 мянган төгрөгийн 5ш тэмдэг дардасыг бараа материалын дансанд бүртгэж тайлагнасан байна.

Өмнөх онд 27 сумын статистик хариуцсан ажилтан, 97 багийн Засаг дарга нарт зориулсан ХАӨМС, Малын тооллого, ХАА ААНБ-ын жил, улирал, сарын цахим программ хангамжийн талаар мэдлэг олгох, үйл ажиллагаандаа хэрэглэх чадвар эзэмшүүлэх сургалтад зориулагдсан бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр зардлын 16,418.0 мянган төгрөгийг, цар тахлын хөл хорио цээрээс шалтгаалан хойшлогдож, санхүүжилтийн орлого нь татан төвлөрүүлэгдсэн тул 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэн авлагыг барагдуулж ҮСХ-оос 2021 оны 3 дугаар сарын 16-нд сургалт зохион байгуулах зориулалттай санхүүжилт ирсэн.

Нэмэлт санхүүжилтээс зориулалт бусаар хөрөнгө бэлтгэж, хэлтсийн даргын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/04 тоот тушаалаар "Сорос компьютер" ХХК-аас 1ш олон үйлдэлт принтер 1,250.0 мянган төгрөгөөр, Ай Ти Зон ХХК-аас 2ш зөөврийн компьютер, 1ш суурийн компьютер 11,619.4 мянган төгрөгөөр, нийт 12,689.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг худалдан авч бэлтгэсэн нь ТӨБЗГ-ын 2019 оны 271-р тогтоолоор батлагдсан журмын 3.3.-д "Төрийн өмчит хуулийн этгээдэд эд хөрөнгө худалдан авах зөвшөөрөл олгох, үнийн дээд хязгаарыг тогтоохдоо эрх бүхий байгууллагаас баталсан төсөв болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан эх үүсвэрийг баримтална." гэж заасантай нийцэхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллийг хугацаанд нь 100 хувь бүрэн байршуулсан, хугацаа хоцроосон мэдээлэл байхгүй, хугацаа нь болоогүй 2 мэдээлэл байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.2-д “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх” зарчмуудыг хангаж, холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар байгууллагын нягтлан бодогчийн ажил үүргийг хавсруулан хувааж гүйцэтгүүлэхгүй байх албан шаардлага хүргүүлснийг 2021 оны 10 дугаар сарын 10-ны Б/04 тушаалаар хэрэгжүүлж 2021 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн №38 тоотой, ажил гүйцэтгэх гэрээгээр ажилласан хөлсөнд нийгмийн даатгалын шимтгэл ногдуулах, эбаримтаар санхүүгийн бүх гүйлгээг баримтжуулах, төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх гэсэн 3 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж Статистикийн хэлтсийн 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн №19 тоот албан бичгээр тус тус ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй ба түлш шатах тослох материалын зарцуулалтыг давтан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 15,906.2 мянган төгрөгийн 3 алдаа зөрчил илэрснээс, 3,036.8 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 12,869.4 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өгөв.

4.1 Залруулсан алдаа

Төсвийн гүйцэтгэлийн тайланд төсвийн тохируулга бүрэн хийгээгүйгээс шалтгаалан зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн гүйцэтгэл 3,036.8 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 8 дугаар зүйлийн 8.1-д “Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар” -ын 8 дугаар заалтыг болон санхүүгийн тайлангийн “оршин байх”, “тохиолдсон байх”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Худалдан авалттай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Нэмэлт санхүүжилтээс зориулалт бусаар хөрөнгө бэлтгэж, хэлтсийн даргын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/04 тоот тушаалаар шийдвэрлэж 12,689.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг худалдан авсан нь ТӨБЗГ-ын 2019 оны 271-р тогтоолоор батлагдсан журмын 3.3-д "Төрийн өмчит хуулийн этгээдэд эд хөрөнгө худалдан авах зөвшөөрөл олгох, үнийн дээд хязгаарыг тогтоохдоо эрх бүхий байгууллагаас баталсан төсөв болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан эх үүсвэрийг баримтална" гэж заасантай болон санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Эрх бүхий байгууллагаас баталсан төсөв болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан эх үүсвэрийг баримталж, зориулалтын дагуу зарцуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс	3	15,906.2	2	3,036.8	0	0.0	0	0.0	1	12,869.4